

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2-3</i>

-
- 1.Хянан шалгах түр хорооны шинжээчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл
 - 2.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын хөлс, шинжээчийн төлбөрийн хэмжээг тогтоох, түр хорооны зардал батлах, зарцуулах эрх олгох тухай тогтоолын төсөл
 - 3.Бусад асуудлын хүрээнд нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл

*Хаалттай
хэлэлцэв*

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 11 дүгээр сарын 22-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 37 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жаргалмаа, С.Ганбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар.

Түр хорооны дарга Б.Энхбаяр хэлэлцэх асуудлуудыг хаалттай хуралдаанаар хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 3
Бүгд: 8
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан хаалттай горимд шилжин хуралдав./15:39/

Нээлттэй хуралдаан 02 минут үргэлжилж, 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60 хувийн ирцтэйгээр 15 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим,
15 цаг 37 минут

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

1.Хянан шалгах түр хорооны шинжээчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл.

2.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын хөлс, шинжээчийн төлбөрийн хэмжээг тогтоох, түр хорооны зардал батлах, зарцуулах эрх олгох тухай тогтоолын төсөл,

3.Бусад асуудлын хүрээнд нотлох баримт гаргуулах тухай тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэж байгаа асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Асуудалдаа орёё.

Өнөөдрийн хуралдаанд 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Хянан шалгах Түр хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр томилсныг танилцуулж байна.

Тогтоолыг нь бүтэн заавал унших шаардлага байгаа юм уу. Энэ чинь тогтоол гарчихсан юм чинь.

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Хэлэлцэж байгаа асуудлууд нь Түр хорооны дотоод асуудал учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт заасныг үндэслэн хаалттай хуралдах горимын саналыг гаргаж байна.

Гишүүдээ дуудаарай. Хаашаа гараад явчлав, байсан гишүүд. Сая Бат-Эрдэнэ гишүүн сая сууж байсан чинь.

Хуралдааныг хаалттай горимоор явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт 62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

15:39 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ